

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ							
1.1 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд ургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зэрэг мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулна.							
1.1.1	Тогтвортой хөгжлийн боловсрол сургалт	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хамрагдсан иргэдийн тоо	976	1000	Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтыг 20 удаа зохион байгуулж, 1007 иргэдийн хамрууллаа.	100%
1.1.2	Цонхон дээрх тариалан олон нийтийн нөлөөллийн ажил	1.275.000	Үйл ажиллагааны хэрэгжилт хамрагдсан иргэдийн тоо	25	35	ХУД-ийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран иргэдэд тогтвортой хөгжлийн боловсрол олгох чиглэлээр “Цонхон дээрх тариалан” нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, 58 иргэнийг хамруулав. Мөн Хан-Уул дүүрэг цонхон дээрх тариалан групп үүсгэн, иргэд туршлагаа хуваалцан ажиллаж байна.	100%
1.1.3	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод, бут тарьж ургуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	73	150	Байгууллагын гадна талбайд 170 ширхэг шар хуйс, 600 ширхэг цэцэг тарьсан.	100%
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ							

2.1. Сургалтын үйлчилгээ

2.1.1	Санхүүгийн боловсролын сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1000	1000	Санхүүгийн боловсрол олгох сургалтыг 41 удаа зохион байгуулж, 1226 иргэнийг хамруулав.	100%
2.1.2	Амьдрах ухааны сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2300	2500	Амьдрах ухааны боловсрол олгох сургалтыг 128 удаа зохион байгуулж 3210 иргэнийг хамруулав.	100%
2.1.3	Бага санхүүжилтээр өрхийн орлогыг дэмжих сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	40	40	Санхүүгийн боловсролын нэг гол ажил нь “Бага санхүүжилтээр өрхийн орлогыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хүрээнд гар урлалын декупаж урлалын сургалтад 16 иргэн, сувсан урлалын сургалтад 11 иргэн, зүү ороосон даалингийн сургалтад 14 иргэн, нийт 41 иргэнийг чадавхжуулах сургалтад хамруулав.	100%
2.1.4	Гэр бүл, эрүүл мэндийн боловсролын сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	3000	3500	Дүүргийн ААН, төрийн болон төрийн байгууллагуудад 72 удаагийн сургалтаар 3520 иргэнийг хамруулав.	100%
2.1.5	Иргэний эрх зүй улс төрийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагааны хүрээнд чанартай боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.	-	Сургалтын үйл ажиллагаа сургалтад хамрагдсан иргэдийн тоо	800	1500	Байгууллагын захиалгаар иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, 1643 иргэнд 112 удаагийн сургалт зохион байгуулсан.	100%
2.1.6	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Дүүргийн хороод, албан байгууллагын захиалгаар жендэрийн эрх, тэгш байдлыг хангах талаар сургалтад хамрагдсан иргэдийн тоо	500	500	2022 онд 46, 121, 28, 35, 144, 300, 165, 190 дүгээр цэцэрлэгүүд, 6, 7, 11, 20, 12 дугаар хороод, Эко тээвэр ОНӨААТҮГ, Монгол наадам цогцолбор, Худалдан авах ажиллагааны алба, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих газар, 32, 41 дүгээр сургуулиудын 584 ажилтан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан.	100%
2.1.7	Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт	-	Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	450	500	Хорт зуршлын сургалтыг Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг МСҮТ-ийн нийт 1045 оюутан суралцагчдад “Архины хор уршиг”, “Тамхины хор уршиг”, “Цахим	100%

						орчны хор уршиг” сэдвийн хүрээнд өртөөчилсөн сургалтын хэлбэрээр зохион байгууллаа.	
2.1.8	Харилцаа, ёс зүйн боловсрол олгох сургалт	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хамрагдсан иргэдийн тоо	2800	3000	Харилцаа, ёс зүйн боловсролын сургалтыг 97 удаа зохион байгуулж, 4208 иргэнийг хамруулав.	100%
2.1.9	Мэргэжил сонголт сургалт	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хамрагдсан иргэдийн тоо	290	600	Мэргэжлээ хэрхэн сонгох вэ? Миний хүүхдийн мэргэжил сонголт сэдвийн хүрээнд цахим, танхимын 35 удаагийн сургалт зохион байгуулж 887 суралцагч сургалтад хамрагдсан.	100%
2.1.10	Соёл, гоо зүйн боловсрол олгох сургалтын хүрээнд чанартай боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэнэ	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	1800	2000	Дүүргийн төрийн ба төрийн бус байгууллагуудын захиалгаар 108 удаагийн сургалтад 3246 иргэн, хүүхэд залуучуудыг хамруулж ажиллалаа.	100%
2.1.11	Бие дааж боловсрол дээшлүүлэх үйлчилгээний хүрээнд танхимын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	150	200	Иргэдийн бие даан боловсролоо дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд танхимын сургалтаар 660 иргэнд үйлчилсэн.	100%
2.1.12	Бие дааж боловсрол дээшлүүлэх үйлчилгээний хүрээнд зөврийн номын сангийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	180	300	Хүүхдийн төв номын сан, Улаанбаатар номын сан, Хангай дээд сургуулийн номын сангуудтай хамтран ажиллаж ном солилцоо болон зөврийн номын сангийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилладаг. Нийт 8 удаагийн зөврийн үйлчилгээгээр 200 ном авч 402 иргэн болон суралцагчид багш ажилчдад үйлчилсэн байна.	100%
2.1.13	Боловсрол нөхөн олгох ангийн сурагчдад уншлагын цагийн хөтөлбөр боловсруулан батлуулж, сургалт зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны үр дүн, хамрагдсан иргэдийн тоо	77	104	Сургалт зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн бага, дунд ангиудад уншлага дэмжих хичээлийг хуваарийн дагуу 3 улирлаар хуваарийн дагуу бага ангид 33 цаг, дунд ангид 33 цагийн хичээл орж, 113 суралцагчдыг бүрэн хамруулав. Суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном сонгон унших, номын соёлыг мэдэх, номтой нөхөрлөх үйл ажиллагааны дагуу хичээлийг зохион байгуулан орж	100%

						сурагчдын унших чадварын судалгаа авч анализ хийж ажилласан.	
2.1.14	Дүүргийн бичиг үсэггүй иргэдийн судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулна.	-	Бичиг үсэггүй иргэдийн 30%	10	12	Манай төв нь жил бүрийн 5 дугаар сард хороодоос бичиг үсэггүй болон сургууль завсардагчдын судалгааг авч, сургалтад хамруулан бичиг үсгийг нь тайлж байна. Энэ хичээлийн жилд бичиг үсэггүй 24–56 насны нийт 53 иргэн байгаагаас анхан шатанд 10, дунд шатанд 2 иргэн суралцлаа.	100%
2.1.15	Сургууль завсардсан хүүхдэд зориулсан танхимын сургалт	-	Суралцагчдын тоо	22	25	2021-2022 хичээлийн жилд боловсрол нөхөн эзэмшихээр нийт 113 хамрагдсанаас танхимын сургалтад 25 хүүхэд суралцав.	100%
2.1.16	Тусгай хэрэгцээт иргэдийн шаардлагатай нийцсэн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх	-	Суралцагчдын тоо	6	8	Жайка ОУБ-тай хамтран 5 багш баг болж, сургуулийн гадна буй хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхэдтэй ажиллаж зохих үр дүнд хүрсэн. Боловсрол нөхөн олгох ангид хөнгөн хэлбэрийн 5, хэвтрийн болон хүнд хэлбэрийн 2 сурагч хамрагдсан. Нийт 13 хүүхдэд хүрч үйлчиллээ.	100%
2.1.17	Насанд хүрэгчдэд зориулсан зайны сургалт	-	Суралцагчдын тоо	68	70	2021-2022 оны хичээлийн жилд бие даасан зайны сургалтад 71 иргэн хамрагдлаа.	100%
2.1.18	Лам хүүхдэд зориулсан танхимын болон зайны сургалт	-	Суралцагчдын тоо	5	6	Наро банчин институтийн дэргэдэх Амарлин хийдийн 6 лам хүүхдийг сургалтад хамруулж, бага ангид-1, дунд ангид-4, ахлах ангид-1 суралцагч суралцаж байна.	100%
2.1.19	Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд Богцон дахь соёлын өв сэдэвт олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	-	150	“Өвийн жим” клубын үйл ажиллагааны хүрээнд Хангай мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 25 суралцагчдад “Дэлхийн өв ба түүний ач холбогдол”, ШУТИС-ийн харьяа МСҮТ-н 30 оюутанд “Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин”, Өвийн жим клубын 32 сурагцагчдад “Өвийн боловсрол”, Герман-Монголын коллежийн 78 суралцагчдад “Дэлхийн өв	100%

						ба түүний ач холбогдол”, “Бидний бахархал” соёлын өвийн үйл ажиллагааг зохион байгуулж 165 суралцагчдад соёлын өвийн талаар мэдээ мэдээлэл, клубын үйл ажиллагаагаа танилцуулан ажиллалаа. Сурагчдын өвийн боловсролыг нэмэгдүүлэх, өв соёлоо мэдэх, түүгээрээ бахархах, хайрлах хамгаалах, бусдадаа зөв үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор Өвийн жим клубээс “Өв бидний бахархал” самбарын үзүүлэн, өв соёлоо танин мэдье аялал зохион байгуулж 25 сурагч оролцлоо.	
2.1.20	Соёл, гоо зүйн боловсролын Богцон дахь соёлын өв сэдэвт сургалт зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	-	150	-Богцон дахь өв соёл хичээлийг 6 сэдвийн хүрээнд Хан -Уул дүүргийн 7-р хорооны 10 албан хаагч нарт “Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин хичээл -ХУД-ийн 5, 12, 13, 14, 15 дугаар хороодын 48 хэсгийн ахлагч нарт өвийн тухай хичээлийг зохион байгуулав. -Албан бус-Насан туршийн боловсролын төвийн сургалтад хамрагдаж буй иргэд 3 удаа 42 иргэнд “Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин” хичээл -Байгууллагын багш ажилчдад “Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин”, баримт бичиг боловсруулах сургалтыг 2 удаа зохион байгуулж 30 албан хаагч хамрагдсан. -Өвийн жим клубын сурагчдад “Өвийн боловсрол” “Дэлхийн өв ба түүний ач холбогдол” дэлхийн өв ба хүрээлэн буй орчин сэдвүүдээр 35 суралцагчдад хичээлийг тус тус зохион байгуулав. Нийт 8 удаагийн сургалтаар 165 хүнд сургалт зохион байгуулсан байна.	100%
2.1.21	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, эрүүл амьдралын хэв маяг, нийтийн биеийн тамирын үйл	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан алба хаагчдын тоо	15	20	-2022 оны 5 сард 19 багш, ажилчдыг ХУД-ийн Спорт хороотой хамтран бие бялдрын хөгжлийн сорилд хамруулсан. -Байгууллагын спорт хамтлагийнхан өглөө	100%

	ажиллагааг хэвшүүлэх					<p>бүр 8:20-8:30 цагт өглөөний дасгал хийж хэвшсэн.</p> <p>-“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” хөтөлбөрт 2 удаа байгууллагаар хамрагдсан.</p> <p>-Дүүргээс зохион байгуулсан “Хамтдаа алхаад эрүүлжье” алхалтаас гадна байгууллагын спортын багаас зохион байгуулсан алхалтад хамт олноороо 3 удаа оролцож эрүүл мэндээ дэмжин ажиллалаа.</p> <p>-2022 оны 09 дүгээр сард нийт багш, ажилтан 15 хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.</p>	
2.2. Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа							
2.2.1	Санхүүгийн боловсролын агуулгын хүрээнд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах	-	Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	80	100	<p>“Мөнгөө ухаалгаар удирдаж, ирээдүйгээ өөрөө бүтээе!” нөлөөллийн ажил 158 иргэн, суралцагч иргэдийн дунд “АХА” тэмцээнд 25 сурагч, “Хуримтлал-Ирээдүй” аяны хүрээнд Хан-Уул дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн 500 эцэг эхэд “Миний хүүхдийн санхүүгийн боловсрол” сургалт зохион байгуулж, мөн Голомт, Худалдаа хөгжлийн банкны Хан-Уул дүүрэг дэх салбаруудтай хамтран “Хуримтлал-Ирээдүй” өдөрлөг зохион байгуулав. Нийт 539 иргэнийг хамруулав.</p>	100%
2.2.2	Гэр бүл, эрүүл мэндийн боловсролын агуулгын хүрээнд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах	-	Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	80	120	<p>2022 онд дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн ерөнхий боловсролын 10 сургуультай хамтран “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” нөлөөллийн ажлыг зохион байгуулж 125 иргэнг хамруулав.</p>	100%
2.2.3	Амьдрах ухааны нөлөөллийн ажил зохион байгуулна	-	Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	80	100	<p>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран өсвөр үеийн охид, хөвгүүдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, идэвхтэй, зорилго</p>	100%

						тэмүүлэлтэй амьдрах, өглөөг үр бүтээмжтэй өнгөрүүлэхэд уриалах зорилгоор “Өөдрөг өглөө” уулзалтыг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, 104 сурагчийг хамруулав. Үйл ажиллагааны хүрээнд уригдан ирсэн өсвөр насны сурагчдад “Дайманд майнд” хүүхэд хөгжлийн академийн сэтгэл зүйч Б.Хэрлэн “Өсвөр нас ба хувь хүний хөгжил” сэдвээр сургалт, ярилцлага хийлээ.	
2.2.4	Иргэний эрх зүйн боловсролын агуулгын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөлөөллийн ажил зохион байгуулна.	-	Олон нийтийн үйл ажиллагааны хүртээмж хамрагдсан иргэдийн тоо.	100	120	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аяны хүрээнд “Нандин бүхнээ хамгаалъя-өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” уриан доор 140 иргэнд хороодын теле дэлгэц болон цахим хуудсаар дамжуулан жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан таниулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.	100%
2.2.5	Харилцаа, ёс зүйн боловсролын олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хамрагдсан иргэдийн тоо	80	100	Боловсролын салбар 2022 оныг Ёс зүйн жил болгон зарласантай холбогдуулан ёс зүйн сайн туршлагыг түгээх, ёс зүйн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн 9 дүүргийн Насан туршийн боловсролын төвүүдийн дунд Багш мэргэжлийн ёс зүй”, “Багшийн ёс зүй”-н талаарх сургалтыг МУИС-ийн багш доктор, профессор Р.Дарьхүү зохион байгуулж сургалтад дүүргүүдийн АБНТБТ-ийн 98 багш нар хамрагдан, туршлага солилцон, хамтран Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн “Өөрчлөлтийг-Өөрөөсөө”, “Хүндлэлээр -хүмүүжье” нөлөөлийн 2 удаагийн ажлаар 403	100%

						иргэдэд хүрч үйлчилсэн	
2.2.6	Мэргэжил нөлөөллийн ажил сонголтын	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хамрагдсан иргэдийн тоо	0	120	Өсвөр насныханд мэргэжлээ хэрхэн зөв сонгох, сонгосон мэргэжилдээ эзэн байх талаар нөлөөллийн ажил зохион байгуулж, өөрийн сонгосон мэргэжлээрээ ажиллаж байгаа болон суралцаж буй оюутнуудтай 2 видео хичээл, Сүлжээний инженер, Төслийн менежер, Геологич, График дизайнер, Маркетингийн менежер, Архитектор зэрэг 6 мэргэжлийн танилцуулга постер цахим хуудаст оруулсан бөгөөд энэ нь 2489 хүнд хүрсэн. Мэргэжил сонголт хийхдээ анхаарах зүйлсийн зөвлөмжийн 8 постерыг цахим хуудаст нийтэлж энэ нь 607 хүнд хүрсэн.	
2.2.7	Соёл, гоо зүйн боловсрол олгох сургалтын агуулгын хүрээнд иргэд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	80	80	Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутан, залуучуудад хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох, үзэл бодлоо илэрхийлэх, хотын соёлд эергээр нөлөөлөх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран “Хотын соёл-Хорт зуршил” илтгэлийн уралдааныг 6 сургуулийн оюутнуудын дунд зохион байгууллаа. Нийт 140 оюутан залуучууд оюун ухаан мэдлэг чадвараараа өрсөлдсөн.	100%
2.2.8	Бие дааж боловсрол дээшлүүлэх үйлчилгээний ном хож нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	0	80	Байгууллагын багш ажилчид, мэргэжлийн сургалтад сууж байгаа суралцагч нийт 82 иргэдийн дунд дэлхийн номын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, номын соёлыг таниулах, номын фондыг нэмэгдүүлэх зорилгоор “Ном хож” асуулт хариултын танин мэдэхүйн нөлөөллийн ажлаар тэмцээн зохион байгуулж “Ном уншъя”	100%

						facebook группыг нээн ажиллуулж түүгээрээ уншигчдад номтой холбоотой мэдээ мэдээллээр үйлчилж байна. Энэ групп нь одоогоор 270 гаруй гишүүнтэй бөгөөд гишүүдийнхээ тоо, идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор “Цагаан бороо” номын шагналтай болзолт уралдаан зарлан ялагчийг тодруулан шагнасан.	
2.3. Цар тахлын үеийн бэлэн байдал							
2.3.1	Ковид–19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.	Төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт	150.000	500.000	Эрсдэлийн үед хэрхэн ажиллах төлөвлөгөө гарган хэлэлцүүлж, батлуулан мөрдөн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай 882,728 төгрөгийг зарцуулсан байна.	100%
2.4. Хотын соёл							
2.4.1	“Хотын соёл” аяны хүрээнд цуврал контент, видео шторк бэлтгэж талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	5	5	“Хотын соёл” аяны хүрээнд “Дохионы хэлийг соёл болгоё” 1 хичээлийг байршуулсан. Соёл, гоо зүйн боловсролын 2 бичлэг, 16 постерыг байгууллагын пэйж болон группт байршуулсан. Уг бичлэг, постерт 3127 иргэн хандаж, 347 лайк дарж, 162 шэйр хийгдсэн байна.	100%
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ							
3.1. Ухаалаг төрийн үйлчилгээ							
3.1.1	Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	100%	Баримтад цахим хувь үйлдэх, бүх шатны байгууллагаас архивын мэдээлэл-лавлагааг онлайн хэлбэрээр авах, ашиглуулах нөхцөлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын: А-тушаал 36 (хавсралт- хуудас) нийт 66 хуудас, Б тушаал 47 нийт 47 хуудас, бүгд	100%

						83 тушаал (хавсралт-113 хуудас) нийт 149 хуудас баримтыг Archive Edoc программд оруулан хянуулсан.	
3.1.2	Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн төр захиргааны байгууллагын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилт, Албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн /Шинэчилсэн найруулга 2020.04.24/ хэрэгжилт	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан	1	1	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам болон холбогдох эрх зүйн актуудыг дагаж мөрдөж ажиллаж байна. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу ирсэн бичиг 206, явсан 92 бичгийг бүртгэж шийдвэрлэн, хяналт тавих, албан хэрэг хөтлөлтийн шатанд хадгалан ашиглаж, хөтлөх нэрийн жагсаалтын дагуу албан хэрэг бүрдүүлэх, ERP системд албан бичиг боловсруулах зэрэг ажлыг хийж байна.	100%
3.1.3	Дүүргээс аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	11	50	2022 оны 1 дүгээр сараас байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах зорилгоор байгууллага дээр сар бүр зохион байгуулагддаг мэргэжлийн анхан шатны сургалтын бүртгэлийг цахимжуулж, нийт 98 иргэнийг бүртгэлээ.	100%
3.1.4	Чиг үүргийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээллээ тухай бүр дүүргийн албан ёсны /www.khanuul.mn/ веб хуудаст байршуулж, иргэдийг үнэн зөв, шуурхай мэдээллээр ханган, цахим мэдээллийн сувгаар уялдаа	-	Тавьсан мэдээний тоо	21	25	Дүүргийн Khanuul.mn сайтад байгууллагын үйл ажиллагаа, явцын болон сарын мэдээг тогтмол гаргаж жилийн эцсийн байдлаар 12 мэдээ, байгууллагын цахим хуудсанд 235 мэдээ, мэдээллийг оруулж, үйл ажиллагаагаа сурталчлан ажиллалаа.	50%

	холбоотой, нягт хамтран ажиллах.						
3.2. Мэргэшсэн тогтвортой төрийн алба							
3.2.1	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	100%	Байгууллагын сурган хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу багш нар дээд газраас зохион байгуулсан 589 цагийн сургалт, байгууллагаас зохион байгуулсан 434 цагийн сургалтад хамрагдаж бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд 293 цагийг зориулсан байна.	100%
3.2.2	Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулна.	төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	100%	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Хан-Уул дүүргийн 46, 121, 35 дүгээр цэцэрлэгүүд, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хаалттай 401 дүгээр ангийн албан хаагчид, Худалдан авах ажиллагааны алба, Нийслэлийн Ерөнхий боловсролын 32, 34 дүгээр сургуулиудын багш, ажилчдад Авлига болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, ЕБС-ийн 41 дүгээр сургуулийн 8 дугаар ангийн сурагчдад Шударга ёсыг хэрхэн хангах вэ? сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж нийт 534 иргэд болон албан хаагч нарт сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж ажиллалаа.	100%
3.2.3	Төрийн байгууллага авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн дээр үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана.	төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	100%	Сар бүрийн 20-ны өдөр нийт багш, ажилтнуудын ажлыг албан тушаалын тодорхойлолтыг үндэслэн сахилга хариуцлага, ёс зүйн алдаа гаргасан эсэхийг нэг үзүүлэлт болгон оруулдаг бөгөөд одоогоор ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтан байхгүй байна.	100%

						Ажлын хариуцлага алдсан тохиолдолд ямар арга хэмжээ авахыг дотоод журамд оруулав.	
3.2.4	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	100%	Сар бүрийн 23-нд ажилчдын ажлыг төлөвлөгөө, тайланд үндэслэн дүгнэж, цалин хөлс, улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг олгож, үнэлгээг ил тод нээлттэй дүгнэж хэвшсэн.	100%
3.2.5	Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	100%	Байгууллага дээр захирлын тушаалаар томилогдсон "Ёс зүйн орон тооны бус зөвлөл" 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Орон тооны бус зөвлөл нь Боловсролын салбар 2022 оныг ёс зүйн жил болгосонтойгоор багш ажилчдаас 2 удаа санал асуулга авч, ажлын төлөвлөгөө боловсруулан, сургалт зохион байгуулан ажиллаж байна.	100%
3.2.6	Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, сургалтад хамруулж мэргэшүүлнэ.	-	Бүх ажилтан албан хаагч, багш нар	3	5	Байгууллагын албан хаагчдыг сурган хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллаж байна. Сар бүр сургалтын алба 2 удаа арга зүйн цагийг зохион байгуулж багш нараа чадавхжуулдаг. 2022 оны 04 дүгээр сард 2 багшид тэргүүлэх болон заах аргач зэрэг олгож ажилласан. Багш С.Энхзаяа МУБИС-ийн Насан турш, зайны тэнхимд магистраар суралцаж байна. Байгууллага 2019-2023 оны сурган хөгжүүлэх хөтөлбөртэй. Хөтөлбөрт заагдсан үйл ажиллагааг жил жилээр төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт	100%

						тавьж ажилладаг. 2022 оны Сурган хөгжүүлэх төлөвлөгөө нь 2 үндсэн зорилтын хүрээнд 11 ажлыг төлөвлөж 100% хэрэгжүүлэн ажиллав.	
3.2.7	Багш ажилчдыг сургалтын техник, тоног төхөөрөмжөөр хангах	7.532.0	Техник тоног төхөөрөмжийн тоо	3	3	2022 оны 01 дүгээр сард багш Г.Түвшинжаргал, Г.Саруул, Ц.Дуламсүрэн нарт notebook, цахим хичээл бичих багц хэрэгсэл, өсгөгчийг 7.532.000 мянган төгрөгийн сургалтын техник, тоног төхөөрөмжөөр хангасан.	100%
3.3 Иргэдийн аюулгүй, амар тайван байдал							
3.3.1	Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрсдэлд өртөхөөс хамгаалах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	80%	-Суралцагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хөдөлгөөнд оролцох тухай сургалтын үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн Замын цагдаатай хамтран зохион байгууллаа. Сургалтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахин аюулгүй байдлаа ханган замын хөдөлгөөнд оролцож зорчих болон иргэн бүрийн мэдэж байвал зохих замын хөдөлгөөний дүрмийг танилцууллаа. -Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн нийт 22 суралцагчаас эрсдэлийн үнэлгээг тооцох зорилготой судалгааг анги удирдсан багш нартай хамтран авсан. Уг судалгаагаар өндөр эрсдэлтэй суралцагч байхгүй, дунд эрсдэлтэй суралцагч 5, бага эрсдэлтэй суралцагч 17 байсан. Дунд эрсдэлтэй эцэг эх болон суралцагчдад “Биеэ авч явах соёл”, “Эерэг харилцаа” сургалтыг багш нартай хамтран зохион байгуулсан. Мөн суралцагчдын ар гэрээр очиж, амьдрал ахуйн байдалтай танилцаж, хичээлд оролцоогүй үеийн даалгаврыг цаасаар өгч, биелэлтийг	100%

						шалгаж ажилласан.	
3.3.2	Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	3	5	Захирлын тушаалаар томилогдсон “Байгууллагын эцэг эхийн зөвлөл” нь журмыг танилцуулж, төлөвлөгөө гарган, мөрдөн ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдаас судалгаа авч гэр бүлийн талаарх мэдээллийн сантай болсон. Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогт тохируулан ажиллах нь сэдэв”-т сургалтыг 19 багш, ажилчдад зохион байгуулав.	100%
ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖИЛ – ӨРХ БҮРТ							
4.1 Боловсрол							
4.1.1	Байгууллагын багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Багш” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%	2021 оны 9 сард сургалтын албаар хэлэлцүүлэн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулан, мөрдөн ажиллаж байна. Насан туршийн боловсролын багш нарын дунд зохион байгуулагдсан ур чадварын уралдаанд оролцож 3 дугаар байр эзэлсэн багш А.Болормаагийн заах арга зүйг дүүргийн багш нарын дунд зохион байгуулах ажлыг хийлээ.	100%
4.1.2	Сургууль, эцэг эх сурагчдын хооронд мэдээлэл солилцох сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	45	90	Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн суралцагчдын дунд цахим хаяг нээж, замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэргээс сэргийлэх, болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах гэх зэрэг мэдээллүүдийг зурган болоод бичлэг хэлбэрээр тогтмол хүргэж, тухайн мэдээллийг танхимын хэлбэрээр тайлбарлан ярилцаж ажилласан.	100%
4.1.3	Ерөнхий боловсролын	-	Сургалтад хамрагдсан	1	4	Жайка ОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн	100%

	сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, ХБХ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.		багшийн тоо			“Сургуулийн гадна буй хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах явуулын багш” төсөлд 5 багшийг хамруулж ХБХ-тэй ажиллах арга зүйд сургалаа.	
4.3 Хөдөлмөр эрхлэлт							
4.3.1	Оёдол, эсгүүрийн мэргэжлийн сургалт	-	Сургалтад хамрагдагсдын тоо	98	100	2022 онд дүүргийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн өрхийн орлогыг дэмжих зорилгоор сар бүр оёдол эсгүүрийн сургалтыг зохион байгуулж 10 удаагийн сургалт 103 иргэнг хамруулсан байна.	100%
4.3.2	Үсчний мэргэжлийн сургалт	-	Сургалтад хамрагдагсдын тоо	70	80	2022 оны жилийн байдлаар дүүргийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн өрхийн орлогыг дэмжих зорилгоор сар бүр үсчний сургалтыг зохион байгуулж 7 удаагийн сургалт 52 иргэнийг хамруулсан байна.	65%
4.3.3	Компьютерын насанд хүрэгчдийн анхан, дунд шатны сургалт зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	120	120	Дүүргийн иргэдийн мэдээллийн технологийн чадварыг сайжруулах зорилгоор сар бүр зохион байгуулсан сургалтад нийт 193 иргэнийг хамруулав.	100%
4.3.4	Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн ангийн сурагчдад компьютерын сургалт зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны үр дүн, хамрагдсан иргэдийн тоо	70	85	Боловсрол нөхөн олгох ангийн танхимаар хичээллэж буй 25, зайнаас суралцаж буй 75 сурагчдад компьютерын хичээлийг хуваарийн дагуу явуулсан.	100%
4.3.5	Дүүргийн иргэдэд солонгос хэлний анхан шатны ярих чадвар хөгжүүлэх сургалтыг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	45	70	2022 онд Хан-Уул дүүргийн иргэдэд солонгос хэлний сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, 9 удаагийн элсэлтээр нийт 73 иргэнд солонгос хэлний анхан шатны мэдлэг олгосон байна.	100%
4.3.6	Англи хэлний анхан, дунд шатны сургалт зохион	-	Сургалтад хамрагдагсдын тоо	270	300	Англи хэлний 2022 оны сургалт амжилттай зохион байгуулагдсан бөгөөд сургалтыг анхан шатны унших, бичих, ярих, сонсох,	100%

	байгуулна.					4 дадал дээр тулгуурлаж англи хэлний анхан шатны мэдлэг олгох түвшинд зохион байгуулж 31 удаагийн сургалтаар нийт 504 иргэн хамрагдан амжилттай суралцаж төгссөн.	
4.4. Дүүргийн төсөв, санхүү							
4.4.1	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	12	12	2022 оны төсвийн хуваарийн дагуу, эдийн засгийн ангилал бүрээр хийж гүйцэтгэн, шилэн дансанд оруулж, зарцуулалтыг ил тод нээлттэй самбарт байршуулан ажиллаж байна.	100%
4.4.2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өмч ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	2	2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, эд хариуцагч нарын хариуцаж буй эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг сайжруулж, ашиглаж буй байдал хяналт тавьж, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэгийн тооллого явуулж тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв чанартай сайн гүйцэтгэж ажилласан.	100%
4.4.3	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, авлага өр, төлбөр үүсгэхгүй байх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах	-	Өр авлагагүй тайлан үнэн зөв хугацаандаа гаргасан байна	100%	100%	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж харилцагч байгууллага болон ажилчдад өр, авлагагүй ажиллаж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж сар бүрийн 1, 2-нд тайлагнаж ажиллаж байна.	100%
4.4.4	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн	-	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж	-	2	Худалдан авах ажиллагаа хийгдээгүй болно.	0%

	бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.		худалдан авалтийн тоо				
4.5 Гэр бүл							
4.5.1	“Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн авьяасыг хөгжүүлж дугуйланд хамруулна.	-	Үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо	0	10	Дүүргийн Спорт хорооны дэргэдэх жудогийн секцэд 4, гар бөмбөгийн секцэд 4. Компьютерын дугуйланд 10, Зохиое, бүтээе оёдлын сургалт-10 сурагч хамрагдаж байна	100%
ТАВ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
5.1.1	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	4	7	-2022 онд Монгол бичгийн анхан, дунд, шатны сургалтад нийт 5 албан байгууллагын 237 иргэд хамрагдсан. Танхимын сургалтад нийт 193 төрийн албан хаагч хамрагдаж, цахим сургалтад 44 иргэн хамрагдсан байна. Сургалтад хамрагдаж буй нийт суралцагчдаас түвшин тогтоох шалгалт 1 удаа, явцын шалгалт 2 удаа, хэрэгцээний болон сэтгэл сэтгэл ханамжийн судалгаа нийт 3 удаа авч сургалтын чанар, агуулгыг сайжруулан, үр дүнтэй суралцахад чиглүүлэн ажилласан. Мөн сургалтад ашиглагдах унших эх, бичих эх, цахим хэрэглэгдэхүүн, бие даан ажиллах дасгал, чиглүүлэгчтэй дасгал зэрэг 6 төрлийн 90 гаруй дасгал даалгаврыг боловсруулан суралцагчдаар ажиллуулсан байна.	100%
5.1.2	Англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	2	4	Англи хэлний сургалтыг анхан шатны унших, бичих, ярих, сонсох, 4 дадал дээр тулгуурлаж англи хэлний анхан шатны мэдлэг олгох түвшинд зохион байгуулж 31 удаагийн сургалтаар нийт 504 иргэн хамрагдан амжилттай суралцаж төгссөн. 10 цахим хичээл, 145 хэрэглэгдэхүүн бэлтгэлээ.	100%

5.1.3	Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	2	3	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2022 онд Жендэрийн эрх, тэгш байдлын хангах тухай хуулийн хүрээнд 584, Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлийн хүрээнд 534, бусад хууль эрх зүйн агуулгын хүрээнд 1643, архи тамхины эсрэг хуулийн агуулгын хүрээнд, нийт 3706 иргэнд мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилго бүхий сургалтын үйл ажиллагааг зохион байгуулжээ.	100%
5.1.4	Хүүхэд хөгжил, хамгаалал хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	9	9	<p>-Бага ангийн суралцагчдын хичээлд ирэлт, гэртээ харих цагт хяналт тавьж гэр бүлийн хүчирхийллийн байдлыг асуулгаар судлан ажиглаж, тэмдэглэл хөтлөн ажилласан.</p> <p>-Сурагч бүртэй буюу нийт 17 суралцагчтай ганцаарчлан уулзаж, сэтгэл зүйн байдлыг судалж, ажиглалт хийж ажиллалаа.</p> <p>-Сурагч М. Баярбаатарын сэтгэл зүйд дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>-Суралцагчдын хичээлд шаардлагатай сурах бичгийг номын сангаас тогтмол үнэ төлбөргүй олгож ажилладаг. Мөн хүүхдийн номын ордноос суралцагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурлан захиалгын номоор хангаж ажилладаг.</p> <p>-Сурагч Б.Удвалд шинэ тэргэнцэр авахад тусалсан, 2 сурагчийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвд хэвтүүлэн эмчлүүлсэн.</p> <p>-2022 оны 04 сарын 07-ны өдөр Боловсрол нөхөн эзэмшихээр танхимаар суралцаж буй суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдад байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, суралцагчдын хичээллэлтийн явц, дугуйлан, секц, мэргэжлийн сургалтуудад хамрагдсан байдлыг танилцуулав.</p>	100%

						<p>-2022-2023 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн Спорт хороонд явагддаг Гар бөмбөг болон чөлөөт бөхийн секцэнд нийт 6 суралцагчдыг үнэ төлбөргүй суралцуулж байна.</p> <p>-Holt international Олон Улсын байгууллагын “Халуун хоол” хөтөлбөрийн хүрээнд 3 суралцагчийн ар гэрт хүнсний дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.</p> <p>-Яаралтай бөгөөд шаардлагатай үед холбогдох утасны жагсаалтыг өдөр тутамдаа авч явах боломжтой карт хэлбэрээр бэлтгэж өгсөн.</p> <p>-Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн ангийн суралцагчдын эцэг, эх асран хамгаалагчдад гурвалсан гэрээг танилцуулж, гэрээнд харилцан гарын үсэг зурж баталгаажуулсан.</p> <p>-Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор “Шар дарцаг” аяны хүрээнд нийт суралцагчдын цүнхэнд оёж тогтоох цацруулагчийг авч өгч ажилласан. Мөн бага ангийн суралцагчдад зам хөндлөн гарахдаа ашиглах шар дарцагыг хүлээлгэн өгсөн.</p> <p>-БНО хөтөлбөрийн сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.</p>	
5.1.5	Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хамрагдсан иргэдийн тоо	2	3	<p>-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Хан-Уул дүүргийн 46, 121, 35 дүгээр цэцэрлэгүүд, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хаалттай 401 дүгээр ангийн албан хаагчид, Худалдан авах ажиллагааны алба, Нийслэлийн Ерөнхий боловсролын 32, 34 дүгээр сургуулиудын багш, ажилчдад Авлига болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 453 иргэд болон албан хаагч нарт сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж</p>	100%

						ажиллалаа. -ЕБС-ийн 41 дүгээр сургуулийн 8 дугаар ангийн 81 сурагчдад Шударга ёсыг хэрхэн хангах вэ? сэдэвт сургалтыг зохион байгуулсан. -Авлигын үндэсний хөтөлбөрийн байгууллагын мэдээллийн самбарт зөвлөмж, мэдээлэл байршуулж, иргэдэд мэдээллийг түгээж ажилласан.	
5.1.6	Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	3	4	Тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр “Тогтвортой хэрэглээ”, “Цэнхэр алтны ухаалаг хэрэглээ”, “Хөрсний бохирдол, түүнийг бууруулах арга зам”, “Экологийн ул мөр” сэдвээр сургалт зохион байгуулж 1007 хүнд хүрсэн байна. Тогтвортой хөгжлийн боловсролын хүрээнд 4 өртөөчилсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан сайжруулсан. Цонхон дээрх тариалан нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Байгууллагын гадна 170 мод, 600 цэцэг тарьсан.	100%
ЗУРГАА. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ							
6.1	Ажиллах орчин нөхцөл сайжруулах	Төсөв	Орчны тохижилт	0	1	Иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор Үүдний 2 самбар, Тогтвортой хөгжлийн боловсролын 17 зорилтын, Гадна хаягжилт хийгдсэн.	100%
6.2	Тусгай хэрэгцээт боловсролын хэрэгцээ онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг хийх, тохижуулж ажиллана.	Төсөв	Орчны тохижилт	0	1	Харааны бэрхшээлтэй хүүхэд уншиж болох брайль 6 үлгэрийн номтой болж номын сангийн фонтыг нэмэгдүүлсэн. Харааны бэрхшээлтэй иргэд компьютер ашиглах, компьютер дээр шивэх болон бусад байдлаар ашиглахад туслах NVDA компьютерын программтай болж харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэхэд бэлтгэсэн.	100%

						Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, сургуулийн гадна буй сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургалт ороход дэмжих зорилгоор тусгай өрөөтэй болсон ба тус өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон ширээ сандал, тайвшруулах булан, жижиг том булчин хөгжүүлэх дасгалын модон хэрэглэгдэхүүн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан модон тоглоом, эсгий ном зэргийг авч байршууллаа.	
6.3	Боловсрол нөхөн олгох ангийг тохижуулах	Төсөв	Орчны тохижилт	0	1	Боловсрол нөхөн олгох ангийн засварыг хийсэн.	100%
6.4	Хоггүй Хан-Уул дэд хөтөлбөрт тусгасан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулахад хамтран ажиллах, хог хаягдал ангилан ялгах савтай болно.	Төсөв	Орчны тохижилт	0	3	Байгууллагын хэмжээнд 3 өнгийн хогийн савыг байршуулж ажиллалаа.	100%
ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ, МЭДЭЭЛЛИЙГ БҮХ ШАТАНД БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ							
7.1	Байгууллагын веб хөгжүүлэх	-	Үйл ажиллагааны мэдээлэл оруулсан тоо	78	90	Байгууллагын веб /www.hudabntbt.edu.mn/ үйл ажиллагааны цэсийг хөгжүүлэхэд илүү чиглэн ажиллаж байна. Энэхүү хэсэгт байгууллагынхаа онцлог, сургалт зохион байгуулдаг багш ажилчдын мэдээллийг шинэчиллээ. Ил тод байдлын үйл ажиллагааг веб хуудсанд дараах цэснүүдэд байршуулан, сайжруулж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн ил тод байдал • Байгууллагын ил тод байдал • Байгууллагын чиг үүрэг үзүүлэлт үнэлгээ • Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ • Урам гэсэн 5 бүлэг хэсэгт хамааруулан байгууллагын төлөвлөгөө тайлан, зорилго, 	

						зорилт нээлттэй ажлын байрны зар, ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, албан хаагчдын ажил гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах үйл ажиллагааны ил тод, дэлгэрэнгүй байршуулж ажиллав. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй мэдээлэл хүргэх зорилгоор Тусгай боловсрол цэс, иргэдийн сургалт, үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг авах зорилгоор санал, хүсэлт цэсийг шинээр боловсруулав. Байгууллагын ил тод байдлын хүрээнд мэдээллийн тогтмол шинэчлэн 101 мэдээллийг байршуулсан.	100%
7.2	Байгууллагын пэйж-ийг хөгжүүлэх	-	Үйл ажиллагааны мэдээлэл оруулсан тоо	89	120	Байгууллагын пэйж (Хан-Уул дүүргийн Насан туршийн боловсролын төв)-байгууллагын бүхий л ажлын үйл явцын мэдээллийг цаг тухай бүрт нь пэйж хуудсанд байршуулан, хуваалцаж түгээн ажиллаж байна. Одоогийн байдлаар 4333 дагагчтай байгаа нь 12 сартай харьцуулбал дагагчдын тоо 1081-аар өслөө. 2022 оны 01 дүгээр сараас байгууллагын пэйж хуудаст -Цаг үеийн постер – 114 -Контент видеонууд-10 -Сургалт үйл ажиллагааны мэдээлэл, олон нийтийн үйл ажиллагаа - 235 мэдээ, мэдээллийг байршуулж 177948 хүний хандалт авсан.	
7.3	Боловсролын салбарын мэдээллийн системд хүсэлт гаргасан сурагчдыг бүртгэж баталгаажуулах /esis.edu.mn/	-	Хүсэлт гаргасан иргэдийн тоо	78	104	2021-2022 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох ангид нийт 30 хүүхэд хүсэлт гаргасныг БШУЯ, НБГ-т бичиг баримтыг бүрдүүлэн өгч баталгаажуулсан.	100%
7.4	ТАХ-ын мэдээг үнэн зөв гаргах	-	ТАХ-ын мэдээг хугацаанд нь үнэн зөв	1	1	2022 оны 1 дүгээр сард ТАХ-ийн мэдээг шинэчлэн гаргаж, баталгаажуулсан.	100%

			бөглөх				
7.5	Байгууллага дээрх ДХШҮ-ний ажлыг зохион байгуулах	-	Улирал бүр шалгах	4	4	Захирлын тушаалаар томилогдсон ДХШҮ-ний баг 2022 онд нийт 14 ажил төлөвлөж бүрэн гүйцэтгэж ажиллалаа. Багш ажилчдын ажлын гүйцэтгэлд 2, 5, 10 дугаар сард ДХШҮ хийж, үүрэг даалгавар өгч ажиллалаа. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд багш ажилчдын баримтлах төлөвлөгөө, тайлан, сэтгэл ханамжийн судалгаа, хэрэгцээний судалгаа, хөтөлбөр, бүртгэлийн хуудас, РРТ загварыг шинэчлэн гарын авлага боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн.	100%
НАИМ. БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖИХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ							
8.1 Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд							
8.1.1	“Ерөнхий боловсролын сургуулийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хүрээнд сургуулийн нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж, сурлагын амжилт, чанарыг ахиулна.	-	Сурлагын амжилт, чанарын ахиц	0	1	“Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө”-г өөрийн байгууллагын нөхцөл байдалд тохируулан боловсруулж, мөрдөн ажилласнаар сурагчид дээд газраас зохион байгуулсан 2 удаагийн, дотоодын хөндлөнгийн 4 удаагийн шалгалтаар ахьсан амжилтаар сургуулиа дүүргэлээ. АВ-100%, АВС-58%-тай шалгагдлаа.	100%
8.1.2	Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, 2020-2021 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалтад үзүүлсэн амжилтыг /анхны	-	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж /хэмжээст/ оноо	0	3-оос доошгүй хувиар ахиулна.	Монгол хэлний шалгалтад 11 сурагч хамрагдаж, 100% тэнцлээ. ЭЕШ өгөх 11 сурагчдад давтлагын хуваарь гарган, мэргэжлийн багшаар давтлага өгүүлж байна.	

	оноо, хэмжээст оноо/ ахиулна.						
8.2 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд							
8.2.1	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, багш удирдах ажилтны хууль, эрх зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, ёс зүйн зөрчилгүй хамт олон болно.	-	Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ	0	Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно	Байгууллагын хамт олонд эерэг харилцаа хандлага сэдвээр сургалт зохион байгуулж, хамт олны уур амьсгалыг сайжруулах зорилгоор 2 удаа ёс зүй харилцаа хандлагын чиглэлээр судалгаа авсан. Байгууллагын соёлыг хэлэлцэх “Өглөөний цай” үйл ажиллагаа зохион байгуулж, өмнөх судалгааны үр дүнг танилцуулж, цаашид мөрдөн ажиллах журам боловсруулсан. Бүх албан хаагчид шинэчлэгдсэн “Хөдөлмөрийн тухай хууль”-ийг судлан бусдадаа танилцуулж, байгууллагын хөдөлмөрийн гэрээг шинэчиллээ.	100%
8.2.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадваржуулахад дэмжлэг үзүүлэх, тэдэнд холбогдох хууль, тогтоомжид заасан нэмэгдэл, урамшуулал олгоно.	-	Нэмэгдэл, урамшуулал олгосон байдал	0	Тухайн жилд урамшуулал олгосон багшийн тоо	Тусгай хэрэгцээт боловсролын багшид 10%-ийн нэмэгдэл сар бүр олгодог.	100%
8.3 Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд							
8.3.1	Хүүхдийн эрх, хамгаалал болон сургуулийн орчин дахь дээрэлхэлт, гадуурхал, аюулгүй байдлын зөрчил дутагдал гаргахгүй ажиллана.	-	Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ	0	Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно	Хүүхдийн эрх, хамгаалал болон сургуулийн орчин дахь дээрэлхэлт дарамтыг илрүүлэх зорилготой “Үе тэнгийнхний дээрэлхэлт дарамтыг илрүүлэх” судалгааг боловсрол нөхөн олгох ангийн нийт 25 суралцагчдаас авч, үр дүнд анализ хийвэл нийт ангийн суралцагчдын дунд дээрэлхэлт дарамт байхгүй боловч нийт 58% саналаар ангийн суралцагчид хоорондын эв найрамдал тааруу гэж гарсан. Уг үр дүнд үндэслэн	100%

						суралцагчдын дунд Харилцаа хандлага, өсвөр насныхны онцлогийн талаар сургалт, ярилцлагыг 2-3 удаагийн давтамжтай зохион байгуулж, суралцагч бүртэй уулзалт ярилцлага дахин хийж, үр дүнг ажиглаж ажилласан.	
--	--	--	--	--	--	---	--

Төлөвлөгөөг хянасан:
Хан-Уул дүүргийн Засаг дарга

Төсвийн Ерөнхийлөн захирагч

..... /Ж.Алдаржавхлан/

(огноо)

Тэмдэг

.....

Төлөвлөгөө тайлагнасан:
Захирал

Төсвийн Шууд захирагч

..... /Т.Рэгзэдмаа/

(огноо)

Тэмдэг

.....